БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Шүүх шинжилгээний хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2023/186/-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2023 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br>Аудитор: З.Ганбаатар<br>Утас: 70342716 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn<br>Аудитор:<br>Утас: 70342716 Цахим хаяг: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт.........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.........................................................................................
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..................................................................................
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..................................................................................
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..........................................................................
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.........................
4. Аудитын тайлан .......................................................................................................................
   4.1 Ерөнхий зүйл ..........................................................................................................................
   4.2 Материаллаг байдал ..............................................................................................................
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт................................................................................
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..............................................................
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..................................................................................
5. Аудитын илрүүлэлт ..................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.......................................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 159

танай ______________ны № ______________т

АЙМГИЙН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА П.ЦОГБАДРАХ
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус хэлтэс нь 2022 онд орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжих ажил арга хэмжээний хүрээнд Булган аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/320 дугаартай захирамжийн хүрээнд орон нутгийн төсвөөс 60,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий орон сууцыг бэлтгүүлэн санхүүгийн тайлангийн барилга байгууламж дансанд орлогод авч бүртгэсэн.

Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дугаартай тогтоолоор 4,421.5 мянган төгрөгийн үнэтэй , 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-1/2482 дугаартай албан бичгээр 11,027.6 мянган төгрөгийн үнэтэй техник хэрэгслүүдийг тус бүр шилжүүлэн авч, машин тоног төхөөрөмж дансанд нийт 15,449.2 мянган төгрөгийн техник хэрэгслүүдийг орлогод аван ажилласан байна.

006020195

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилтын хүрээнд 70 ажил төлөвлөснөөс 70 ажлыг биелүүлж биелэлт 96.4 хувийн биелэлттэйгээр тайлагнасан байна.

2022 онд улсын төсвөөс 187,276.9, үйл ажиллагааны орлого 3,136.0, нэмэлт санхүүжилтээр 1,516.6 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан, 2022 онд авлага, өглөгийн данс нь эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал илрээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

6317144798
ГЮА0048 3190269

**СТ-1А**

# САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,953,960.00** | **5,860,960.00** |
| **33** | **АВЛАГА** | **0** | **495,000.00** |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 0 | 495,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 4,953,960.00 | **5,365,960.00** |
| **351** | **Түүхий эд материал** | 996,060.00 | 1,417,060.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 573,000.00 | 573,000.00 |
| 35130 | Эм боох материал | 423,060.00 | 844,060.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 3,957,900.00 | 3,948,900.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 143,400.00 | 143,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,814,500.00 | 3,805,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,588,723.24** | **98,258,042.41** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 37,588,723.24 | **98,258,042.41** |
| **392** | **Биет хөрөнгө** | 30,338,723.24 | **91,008,042.41** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 00.00 | 60,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -750,000.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 18,000,000.00 | 18,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -6,600,000.00 | -8,400,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 55,275,150.00 | 70,724,350.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -39,368,969.82 | -49,529,564.96 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,431,324.29 | 11,431,324.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,398,781.23 | -10,468,066.92 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **7,250,000.00** | **7,250,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,250,000.00 | 7,250,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **42,542,683.24** | **104,119,002.41** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **42,542,683.24** | **104,119,002.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 42,542,683.24 | **104,119,002.41** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 10,902,720.00 | 10,902,720.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 10,902,720.00 | 10,902,720.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 31,639,963.24 | 93,216,282.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 31,639,963.24 | 31,639,963.24 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 61,576,319.17 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **42,542,683.24** | **104,119,002.41** |

**СТ-2А**

## САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **179,029,300.00** | **265,932,207.43** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,576,000.00** | **77,404,207.43** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,576,000.00 | **77,404,207.43** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,576,000.00 | 77,404,207.43 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,576,000.00 | 3,136,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 74,268,207.43 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **176,453,300.00** | **188,793,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 168,523,300.00 | 187,276,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 168,523,300.00 | 187,276,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,930,000.00 | 1,516,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,720,000.00 | 876,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,210,000.00 | 640,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **182,419,169.92** | **204,850,888.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **182,419,169.92** | **204,850,888.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 177,171,748.64 | 203,708,583.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 134,116,646.10 | 138,174,851.52 |
| 210101 | Үндсэн цалин | 82,086,161.60 | 96,734,236.35 |
| 210102 | Нэмэгдэл | 42,217,070.48 | 29,633,349.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,813,414.02 | 8,654,205.57 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 3,153,060.10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,294,171.42 | 4,195,412.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 319,719.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 39,999.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 29,753.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 4,440.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,294,171.42 | 3,801,499.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,819,095.20 | 10,771,830.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 624,064.70 | 570,888.20 |
| 210302 | Түлш, халаалт | 4,866,840.50 | 7,203,222.05 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,108,190.00 | 1,197,720.70 |
| 210304 | Байрны түрээс | 2,220,000.00 | 1,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,490,450.00 | 15,702,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 2,401,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,999,250.00 | 9,191,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,042,800.00 | 957,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 20,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,448,400.00 | 3,397,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,766,530.00 | 8,434,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,766,530.00 | 7,898,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 536,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,660,000.00 | 6,911,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 450,000.00 | 411,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,210,000.00 | 6,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,422,100.00 | 3,740,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,422,100.00 | 3,740,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,149,826.00 | 2,445,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800,000.00 | 1,102,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 46,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 254,500.00 | 38,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 10,876.00 | 8,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,452,929.92 | 13,333,388.26 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 9,452,929.92 | 13,333,388.26 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,247,421.28 | 1,142,305.25 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,247,421.28 | 1,142,305.25 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,247,421.28 | 1,142,305.25 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-3,389,869.92** | **61,576,319.17** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-3,389,869.92** | **61,576,319.17** |

**СТ-2А**

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **179,029,300.00** | **191,929,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,576,000.00** | **3,136,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,576,000.00 | 3,136,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,576,000.00 | 3,136,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,576,000.00 | 3,136,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **176,453,300.00** | **188,793,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 168,523,300.00 | 187,276,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 168,523,300.00 | 187,276,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 7,930,000.00 | 1,516,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,720,000.00 | 876,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,210,000.00 | 640,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **176,529,300.00** | **191,929,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **176,529,300.00** | **191,929,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **171,281,878.72** | **190,787,194.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 134,116,646.10 | 138,174,851.52 |
| 210101 | Үндсэн цалин | 82,086,161.60 | 96,734,236.35 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 42,217,070.48 | 29,633,349.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,813,414.02 | 8,654,205.57 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 3,153,060.10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,294,171.42 | 4,195,412.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 00.00 | 319,719.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 39,999.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 29,753.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 4,440.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,294,171.42 | 3,801,499.91 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,819,095.20 | 10,771,830.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 624,064.70 | 570,888.20 |
| 210302 | Түлш, халаалт | 4,866,840.50 | 7,203,222.05 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,108,190.00 | 1,197,720.70 |
| 210304 | Байрны түрээс | 2,220,000.00 | 1,800,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,820,450.00 | 15,743,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 2,401,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,999,250.00 | 8,925,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,042,800.00 | 957,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 20,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,778,400.00 | 3,438,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,999,590.00 | 8,855,700.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,999,590.00 | 8,319,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 536,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,660,000.00 | 6,861,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 450,000.00 | 361,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,210,000.00 | 6,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,422,100.00 | 3,740,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,422,100.00 | 3,740,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,149,826.00 | 2,445,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800,000.00 | 1,102,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 46,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 254,500.00 | 38,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 10,876.00 | 8,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **5,247,421.28** | **1,142,305.25** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,247,421.28 | 1,142,305.25 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,247,421.28 | 1,142,305.25 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,500,000.00** | **00.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,500,000.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,500,000.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,500,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,500,000.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2,500,000.00** | **00.00** |

**СТ-4А**

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,652,720.00 | 00.00 | 12,100,082.85 | 00.00 | 15,752,802.85 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,652,720.00** | **00.00** | **12,100,082.85** | **00.00** | 15,752,802.85 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 479,819.00 | 00.00 | 479,819.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,902,720.00** | **00.00** | **31,639,963.24** | **00.00** | 42,542,683.24 |
| D01 | **2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,902,720.00** | **00.00** | **31,639,963.24** | **00.00** | 42,542,683.24 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **10,902,720.00** | **00.00** | **31,639,963.24** | **00.00** | 42,542,683.24 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 61,576,319.17 | 00.00 | 61,081,319.17 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,902,720.00** | **00.00** | **93,216,282.41** | **00.00** | 104,119,002.41 |

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 189,676,900.00 | 189,270,594.75 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 189,676,900.00 | 189,270,594.75 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 189,676,900.00 | 189,270,594.75 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **138,412,400.00** | **138,174,851.52** |
| 210101 | Үндсэн цалин | 96,735,700.00 | 96,734,236.35 |
| 210102 | Нэмэгдэл | 29,783,900.00 | 29,633,349.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,655,000.00 | 8,654,205.57 |
| 210104 | Урамшуулал | 3,237,800.00 | 3,153,060.10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **4,201,500.00** | **4,195,412.28** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 320,000.00 | 319,719.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 40,000.00 | 39,999.30 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 30,000.00 | 29,753.08 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,000.00 | 4,440.46 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,801,500.00 | 3,801,499.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **10,773,600.00** | **10,771,830.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 571,800.00 | 570,888.20 |
| 210302 | Түлш, халаалт | 7,203,700.00 | 7,203,222.05 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,198,100.00 | 1,197,720.70 |
| 210304 | Байрны түрээс | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,660,600.00** | **14,656,700.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,401,300.00 | 2,401,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,849,700.00 | 8,849,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 957,900.00 | 957,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 24,200.00 | 20,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,427,500.00 | 2,427,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **8,857,100.00** | **8,855,700.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,320,800.00 | 8,319,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 536,300.00 | 536,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,861,100.00** | **6,861,100.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 361,100.00 | 361,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,500,000.00 | 6,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,802,700.00** | **3,740,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,802,700.00 | 3,740,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,107,900.00** | **2,015,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 672,400.00 | 672,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 216,000.00 | 216,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 66,200.00 | 46,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 100,200.00 | 38,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,200.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8,900.00 | 8,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 189,004,500.00 | 190,412,900.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 186,604,500.00 | 187,276,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 186,604,500.00 | 187,276,900.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,400,000.00 | 3,136,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,400,000.00 | 3,136,000.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 09.00 |

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,516,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,516,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,516,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,086,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 75,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,010,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 430,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 430,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1516600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,516,600.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 876,600.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 640,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 зорилтын хүрээнд 70 ажил төлөвлөснөөс 70 ажлыг биелүүлж биелэлт 96.4 хувиар дүгнүүлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол Улсын Шүүхийн Шинжилгээний тухай хуулийн 37.1-д "Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн" гэж заасны дагуу биет баримтыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх үе шат бүрд онцгой анхаарч, үзлэг, шинжилгээг тал бүрээс нь, шинжлэх

ухааны үндэслэлтэй, хуулийн дагуу явуулж, нотлох баримтын эх сурвалжийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулан, улсын хэмжээнд шинжлэн магадлахуйн цогц үйл ажиллагааг бий болгох эрхэм зорилготойгоор үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Өөрөөр хэлбэл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд /хэрэг бүртгэгч, мөрдөгч, прокурор, шүүгч/-ийн тогтоол захирамжаар тэднээс шинжээч, шинжээч эмч нар хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан үйл ажиллагаагаа бие даан явуулдаг.

Албаны үйлчилгээний нэр, төрөл гэвэл:

1. Криминалистикийн шинжилгээний чиглэлээр

- Мөр судлалын шинжилгээ
- Гарын мөрний шинжилгээ
- Галт зэвсгийн шинжилгээ
- Бичиг баримтын шинжилгээ
- Хүний дүр төрхийн шинжилгээ

2. Шүүх эмнэлгийн шинжилгээний чиглэлээр

- Амьд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг шинжилгээ
- Нас барагчийн цогцост хийх шинжилгээ
- Хүний нас тогтоох, эцэг тогтоох, бэлгийн гэмт хэргийн үзлэг шинжилгээ

3. Хими, биологийн шинжилгээний чиглэлээр

- Согтолтын зэрэг тогтоох
- Хордлогын шинж тогтоох /угаарын хий бусад хордлогын/
- Цусны бүлэг тогтоох

4. Сан бүрдүүлэх чиглэлээр

- Гарын хээний “Папилон” системийн сан
- Галт зэвсгийн” Арсеналь” системийн сан
- Гутлын улны мөрний сан
- Тээврийн хэрэгслийн дугуйны мөр, тэнхлэг хоорондын зайн сан гэх мэт .

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,669.3 мянган төгрөгөөр буюу 38.2 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 4,953.9 | 5.365.9 | 400.0 |
| Үндсэн хөрөнгө | 37,588.7 | 98,258.0 | 60,669.3 |
| **Нийт хөрөнгө** | **42,542.6** | **103,624.0** | **2,771.5** |
| Өр төлбөр | | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 42,542.6 | 103,624.0 | 0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **42,542.6** | **103,624.0** | **61,081.4** |

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 400.0, үндсэн хөрөнгө 60,669.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгөөр 30,231.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 29,819.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.Тайлант онд шилжсэн, шилжүүлэн авсан өөрчлөлтгүй, акталж устгасан бараа материал байхгүй болно.

Тус хэлтэс нь 2022 онд орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжих ажил арга хэмжээний хүрээнд Булган аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/320 дугаартай захирамжийн хүрээнд орон нутгийн төсвөөс 60,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий орон сууцыг бэлтгүүлэн санхүүгийн тайлангийн барилга байгууламж дансанд орлогод авч бүртгэсэн.

Мөн Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 14 дугаартай тогтоолоор 4,421.5 мянган төгрөгийн үнэтэй , 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А-1/2482 дугаартай албан бичгээр 11,027.6 мянган төгрөгийн үнэтэй техник хэрэгслүүдийг тус бүр шилжүүлэн авч, машин тоног төхөөрөмж дансанд нийт 15,449.2 мянган төгрөгийн техник хэрэгслүүдийг орлогод аван ажилласан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 103,624.0 мянган төгрөг болж 3,389.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 86,902.7 мянган төгрөгөөр буюу 14.8 хувиар, нийт зардал өмнөх оноос 22,431.7 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар тус тус өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Булган аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,030,122.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,030,122.3 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 840,445.4 мянган төгрөгөөр бууруулан 189,676.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн төслөөр хүргүүлсэн дүнг 840,445.4 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн үйл ажиллагаа явуулах барилгын төсвийн зардлыг бууруулсан нь шалтгаалж байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 187,276.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, нэмэлт санхүүжилтийн орлого 1,516.6 мянган төгрөг, 3,136.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос, урсгал үйл ажиллагаанд 190,787.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,142.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тус онд 190,787.1 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулснаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 138,174.8 мянган төгрөг нийт зардлын 72.4 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,195.4 мянган төгрөг нийт зардлын 2.1 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10,771.8 мянган төгрөг нийт зардлын 5.6 хувь, хангамж бараа материалын зардалд 15,743.3 мянган төгрөг нийт зардлын 8.2 хувь, норматив зардал 8,855.7 мянган төгрөг нийт зардлын 4.6 хувь, хөдөлмөр хамгаалал, урсгал засварын зардалд 6,500.0 мянган төгрөг нийт зардлын 3.4 хувь, дотоод алба томилолтын зардалд 3,740.0 мянган төгрөг нийт зардлын 1.9 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2,445.0 мянган төгрөг нийт зардлын 1.2 хувийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/ | 186,604.50 | 185,462.10 | 1,142.40 | 99.39 |
| 2 | Шүүх шинжилгээний тусгай ажил үйлчилгээ /82311/ | 2,400.0 | 1,516.0 | 884.00 | 63.17 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2022 онд аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны А/589 дугаартай захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 876.6 мянган төгрөгийг, Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 243 дугаартай тушаалаар 640.0 мянган төгрөгийн давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн авч зарцуулсан байна. Нийт нэмэлт санхүүжилтийн дансанд 1,516.0 мянган төгрөгийн орлого орж 1,516.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол , газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 12/31 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 2,878.9 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 2,159.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

*Төрийн хэмнэлтийн тухай хууль хамаарахгүй болно.*

### *4.4 Санхүүгийн тайлангийн* аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тухайн жилд шилэн дансанд мэдээлэх мэдээллийг бүрэн оруулж мэдээлсэн байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0.00 төгрөгийн дансны үнэтэй 63 ширхэг хөрөнгийг тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Булган аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс нь 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 13г/126 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **0** | | **0** | | **0** |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 2 | 0 | 2 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | | **2** | | **100** |

Хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж байхгүй болно.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Дараагийн аудитаар албан томилолтоор ажиллах хугацаанд хоолны мөнгийг давхардуулан олгосон байх,

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 760.5 мянган төгрөгийн 2 алдааг залруулж

Аудитын хугацаанд нэг зөрчилд зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

**5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт бичигдээгүй болно.

**5.2 Албан шаардлага**

Албан шаардлага бичигдээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0.00 төгрөгийн дансны үнэтэй 63 ширхэг хөрөнгийг тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17, Засгийн газрын 2006 оны 388 дугаар тушаалын нягтлан бодох бүртгэлийн зааврын 4.41-т "Биет хөрөнгийн дансны үнэ бодит үнээс материаллаг хэмжээний зөрүүтэй байх нөхцөлд хөрөнгийн дахин үнэлгээг хийнэ" гэж заасантай дагуу гүйцэтгээгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 63 төрлийн төрлийн хөрөнгөд хууль журмын дагуу шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалт ны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0.00 төгрөгийн дансны үнэтэй 63 ширхэг хөрөнгийг тайлагнасан байна. | 1 | 0 | | | | | 0 | 0 | | | | |
| Дүн | 1 | 0 | | | | | 0 | 0 | | | | |